


## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ 7 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 4,900.3 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 7,365.9 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,465.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 3,000.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол төлөвлөсөн дүнгээс 78.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

**График 1.** Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/



2020 оны эхний 7 сарын байдлаар нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 1,013.5 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 233.3 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого 310.6 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн орлого 46.0 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 18.8 хувь буюу 1,134.8 тэрбум төгрөгөөр буурч, төсвийн нийт зарлага 33.9 хувь буюу 1,866.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 15.1 пунктээр их байгаа нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл алдагдалтай гарч, Улсын төсвийн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 3,000.9 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

### Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

#### Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2020 оны эхний 7 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-745.3	808.0	1,345.6	166.5	537.6
Засгийн газрын бонд	-91.6	-133.9	-64.6	48.2	69.4
Засгийн газрын зээл	301.4	1,324.9	1,160.6	87.6	-164.3

Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	478.8	0.0	0.0	-478.8
Өмч хувьчлал	0.3	66.6	24.0	36.0	-42.6
<b>НИЙТ ДҮН</b>	<b>-535.3</b>	<b>2,544.3</b>	<b>2,465.6</b>	<b>96.9</b>	<b>-78.7</b>

Эх сурвалж: Сангийн яам

2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 325.8 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 64.6 тэрбум төгрөг, дотоод зээлийн үндсэн төлбөрт 63.9 тэрбум төгрөг тус тус төлжээ. Харин 716.0 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл болон 834.4 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл шинээр авч, Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд шинээр гаргаагүй байна.

## 2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

*Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 4,900.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 18.8 хувь буюу 1,134.8 тэрбум төгрөгөөр буурсан, мөн тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 21.4 хувь буюу 1,337.5 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.*

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 23.1 хувь буюу 1,013.5 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсөв 20.7 хувь буюу 310.6 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 15.6 хувь буюу 46.0 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсөв 11.1 хувь буюу 233.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Орон нутгийн төсвийн орлого 12.1 хувь буюу 200.7 тэрбум төгрөгөөр өссөн бол харин Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 5.6 хувь буюу 14.8 тэрбум төгрөгөөр, Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 23.7 хувь буюу 1,050.1 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн орлого 12.8 хувь буюу 175.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

### Нэгдсэн төсвийн орлогын 2020 оны 7 дугаар сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Хүснэгт 2.

/тэрбум төгрөг/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,921.2	3,742.0	2,093.6	1,860.3	1,500.2	1,189.6	295.7	249.6
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	69.4	16.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	457.7	344.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,394.1	3,380.6	2,093.6	1,860.3	1,500.2	1,189.6	295.7	249.6
<b>Татварын орлого</b>	<b>3,519.2</b>	<b>2,942.2</b>	<b>821.9</b>	<b>653.1</b>	<b>1,171.3</b>	<b>860.8</b>	<b>295.7</b>	<b>249.6</b>
Орлогын албан татвар	1,015.4	720.9	539.8	438.3	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,171.3	860.8	295.7	249.6
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	115.0	87.9	0.0	0.0	0.0	0.0

Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,217.1	1,127.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	519.1	433.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	8.8	8.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	468.8	399.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	290.0	252.0	167.1	126.9	0.0	0.0	0.0	0.0
<b>Татварын бус орлого</b>	<b>874.9</b>	<b>438.5</b>	<b>1,271.7</b>	<b>1,207.2</b>	<b>328.8</b>	<b>328.8</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Нийтлэг татварын бус орлого	449.1	280.3	143.5	106.9	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.9	0.5	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	210.1	141.1	4.9	4.0	328.8	328.8	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	215.8	17.1	1,122.4	1,095.8	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам




Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 91.7 хувийг татварын орлого, 8.3 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 18.0 хувь буюу 989.6 тэрбум, татварын бус орлого 26.4 хувь буюу 145.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**Татварын орлого 4,495.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 19.4 хувь буюу 1,082.5 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.**

Татварын орлогын 25.8 хувийг орлогын албан татвар, 20.0 хувийг нийгмийн даатгалын орлого, 2.0 хувийг хөрөнгийн албан татвар, 25.1 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.6 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 8.9 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 8.4 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.




Тайлант хугацаанд бүх төрлийн татварын орлогууд буурсан үзүүлэлттэй байна. Үүнд: нийгмийн даатгалын орлого 27.2 хувь /336.7 тэрбум.төг/-иар, орлогын албан татвар 25.5 хувь /396.0 тэрбум.төг/-иар, хөрөнгийн албан татвар 23.5 хувь /27.1 тэрбум.төг/-иар, онцгой албан татвар 16.5 хувь /85.5 тэрбум.төг/-иар, гадаад үйл ажиллагааны орлого 14.7 хувь /68.9 тэрбум.төг/-иар, нэмэгдсэн өртгийн албан татвар 7.4 хувь /89.9 тэрбум.төг/-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**Дутуу төвлөрсөн татварын орлогын 31.1 хувийг нийгмийн даатгалын орлого, 7.9 хувийг онцгой албан татвар, 6.4 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 2.5 хувийг хөрөнгийн албан татвар, 7.2 хувийг бусад татвар, төлбөр хураамж эзэлж байна.**

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2020 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр татварын орлого 989.6 тэрбум төгрөг буюу 18.0 хувиар буурахад онцгой албан татвар 71.8 тэрбум (14.2%), гадаад үйл ажиллагааны орлого 39.2 тэрбум (8.9%), бусад татвар, төлбөр хураамж 155.6 тэрбум (29.1%), орлогын албан татвар 358.1 тэрбум (23.6%), нийгмийн даатгалын орлого 192.3 тэрбум (17.6%), нэмэгдсэн өртгийн албан татвар 163.9 тэрбум (12.7%) төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

**Татварын бус орлого 404.7 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 26.4 хувь буюу 145.1 тэрбум төгрөгөөр буурсан бөгөөд төлөвлөснөөс 255.0 тэрбум төгрөг буюу 38.7 хувиар дутуу төвлөрсөн байна.**

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд газрын тосны орлого 92.2 тэрбум, гадаад хандив тусламжийн орлого 49.2 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 67.4 тэрбум, навигацийн орлого 36.6 тэрбум, түрээсийн орлого 0.3 тэрбум, хувьцааны ноогдол ашиг 23.1 тэрбум, бусад орлого 4.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ.



Татварын бус орлогын 95.7 хувийг нийтлэг татварын бус орлого, 4.2 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийт татварын бус орлогод эзлэх нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 42.5 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 14.0 хувийг навигацийн орлого, 10.5 хувийг хүүгийн орлого, 10.4 хувийг торгуулийн орлого, 8.7 хувийг газрын тосны орлого, 0.8 хувийг хувьцааны ноогдол ашиг, 0.6 хувийг түрээсийн орлого, 12.2 хувийг бусад орлого тус тус эзэлж байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн дагуу нийт 18 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 4 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 14 нь 12.5-100.0 хувь дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна. Татварын ерөнхий газар 19.7 хувиар, Гаалийн ерөнхий газар 15.9 хувиар төлөвлөгөө дутуу биелүүлсэн үзүүлэлттэй байна.

2020 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч,  
түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Хүснэгт 3.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны	2020 оны 07 дугаар сарын гүйцэтгэл			
	мөн үеийн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Сангийн сайд</b>	<b>4,537,199.4</b>	<b>4,411,157.8</b>	<b>3,597,291.7</b>	<b>813,866.1</b>	<b>81.5</b>
Татварын ерөнхий газар	2,686,941.0	2,403,864.1	1,930,347.8	473,516.2	80.3
Үүнээс: Тогтворжуулалтын санд		69,385.1	16,787.9	52,597.2	24.2
Ирээдүйн өв санд		360,377.9	344,578.7	15,799.2	95.6
Гаалийн ерөнхий газар	1,777,571.9	1,892,559.0	1,591,186.2	301,372.7	84.1
Сангийн яам	34,544.6	45,906.7	55,700.1	-9,793.4	121.3
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	33,661.7	66,214.1	17,023.4	49,190.7	25.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,480.2	2,614.0	3,034.1	-420.2	116.1
<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b>	<b>0.0</b>	<b>58.4</b>	<b>0.0</b>	<b>58.4</b>	<b>0.0</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	58.4	0.0	58.4	0.0
<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>4,549.3</b>	<b>94,322.7</b>	<b>9,052.5</b>	<b>85,270.1</b>	<b>9.6</b>
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	2,331.3	88,708.9	4,028.5	84,680.4	4.5
Үүнээс: Ирээдүйн өв санд		79,851.8	0.0	79,851.8	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,218.0	5,613.8	5,024.1	589.8	89.5
<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>6,121.4</b>	<b>8,214.9</b>	<b>10,876.3</b>	<b>-2,661.4</b>	<b>132.4</b>
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2,279.7	2,245.8	1,433.1	812.7	63.8
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,841.7	5,969.0	9,443.2	-3,474.2	158.2
<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>28,949.0</b>	<b>30,805.4</b>	<b>26,959.6</b>	<b>3,845.8</b>	<b>87.5</b>
Улсын бүртгэлийн ерөнхий газар	9,481.9	9,916.7	7,229.8	2,686.9	72.9
Цагдаагийн ерөнхий газар	1,042.5	3,056.7	501.6	2,555.1	16.4
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	4,269.5	6,128.9	4,911.1	1,217.8	80.1
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	14,155.1	11,703.2	14,317.2	-2,613.9	122.3
<b>Гадаад харилцааны сайд</b>	<b>10,933.9</b>	<b>10,699.7</b>	<b>3,073.9</b>	<b>7,625.8</b>	<b>28.7</b>
Дипломат төлөөлөгчийн газрууд	10,654.4	10,208.0	2,889.4	7,318.6	28.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	279.5	491.7	184.5	307.2	37.5
<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>	<b>132,827.6</b>	<b>96,876.0</b>	<b>59,641.6</b>	<b>37,234.4</b>	<b>61.6</b>
Иргэний нисэхийн ерөнхий газар	127,400.0	90,800.0	54,200.0	36,600.0	59.7
Зам, тээврийн хөгжлийн яам	110.0	126.0	108.0	18.0	85.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,317.6	5,950.0	5,333.6	616.4	89.6
<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b>	<b>173,829.3</b>	<b>151,777.1</b>	<b>57,891.9</b>	<b>93,885.3</b>	<b>38.1</b>
Ашигт малтмал, газрын тосны газар	172,734.2	150,269.3	56,981.9	93,287.4	37.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,095.1	1,507.8	910.0	597.8	60.4
<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>47,824.9</b>	<b>58,428.2</b>	<b>41,005.3</b>	<b>17,423.0</b>	<b>70.2</b>

	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	290.0	554.2	0.0	554.2	0.0
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	299.3	465.7	361.4	104.4	77.6
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	47,235.6	57,408.4	40,643.9	16,764.5	70.8
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>		<b>24,073.8</b>	<b>82,420.1</b>	<b>30,673.8</b>	<b>51,746.3</b>	<b>37.2</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	24,073.8	82,420.1	30,673.8	51,746.3	37.2
<b>Эрүүл мэндийн сайд</b>		<b>143,055.7</b>	<b>142,890.5</b>	<b>123,578.3</b>	<b>19,312.2</b>	<b>86.5</b>
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	124,075.4	126,876.6	110,932.5	15,944.1	87.4
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	18,980.3	16,013.9	12,645.8	3,368.1	79.0
<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b>		<b>690.1</b>	<b>196.1</b>	<b>496.0</b>	<b>-299.8</b>	<b>252.9</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	690.1	196.1	496.0	-299.8	252.9
<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>		<b>117.7</b>	<b>70.0</b>	<b>43.7</b>	<b>26.3</b>	<b>62.4</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	117.7	70.0	26.3	0.0	62.4
<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд</b>		<b>4,115.2</b>	<b>2,186.1</b>	<b>1,071.1</b>	<b>1,115.0</b>	<b>49.0</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,115.2	2,186.1	1,071.1	1,115.0	49.0
<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>		<b>790.0</b>	<b>1,282.2</b>	<b>973.3</b>	<b>308.9</b>	<b>75.9</b>
	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	790.0	1,182.2	973.3	208.9	82.3
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0	100.0	0	100.0	0
<b>Батлан хамгаалахын сайд</b>		<b>13,603.9</b>	<b>27,814.9</b>	<b>20,525.3</b>	<b>7,289.6</b>	<b>73.8</b>
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	4,164.4	5,244.8	4,559.2	685.6	86.9
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	9,439.5	22,570.1	15,966.1	6,604.0	70.7
<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>		<b>154.7</b>	<b>70.0</b>	<b>291.0</b>	<b>-221.0</b>	<b>415.7</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	154.7	70.0	291.0	-221.0	415.7
<b>Санхүүгийн зохицуулах хороо</b>		<b>422.0</b>	<b>734.1</b>	<b>1,196.6</b>	<b>-462.5</b>	<b>163.0</b>
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	422.0	734.1	1,196.6	-462.5	163.0

Эх сурвалж: Сангийн яам

### 3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 8,782.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 83.9 хувийг ашиглаж 1,416.3 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,866.1 тэрбум төгрөг буюу 33.9 хувиар өсч 7,365.9 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэл  
/төсвийн шатлалаар/

#### Хүснэгт 4.

/тэрбум төгрөг/

	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.



НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,711.1	5,867.8	2,357.5	1,641.7	1,460.5	1,413.3	298.7	222.9
НИЙТ ЗАРЛАГА	6,629.0	5,846.8	2,330.1	1,631.4	1,460.5	1,413.3	298.7	222.9
УРСГАЛ ЗАРДАЛ	5,099.4	4,642.3	1,801.1	1,354.1	1,460.5	1,413.3	298.7	222.9
Бараа, ажил, үйлчилгээний зардал	1,713.5	1,435.3	1,416.0	1,211.1	16.0	14.5	3.3	2.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	512.4	454.9	4.4	4.4	0.0	0.0	0.0	0.0
Татаас	455.7	442.6	113.8	94.1	0.0	0.0	29.7	21.2
Урсгал шилжүүлэг	2,417.8	2,309.5	266.9	44.5	1,444.5	1,398.9	265.8	199.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,529.6	1,204.5	529.0	277.2	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	82.1	21.0	27.4	10.3	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-2,317.0	-2,487.2	-263.9	218.6	39.6	-223.8	-3.0	26.8

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 843.3 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 715.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 47.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 75.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 1,516.7 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлага 181.0 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 231.6 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 32.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 33.9 хувь буюу 1,866.1 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 82.4 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 1,334.6 тэрбум, хөрөнгийн зардал 613.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

**Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.6 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 57.5 тэрбум төгрөгөөр буюу 11.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.**

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл  
/зардлын эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт 5.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2020 оны эхний 7 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,499.8</b>	<b>8,782.1</b>	<b>7,365.9</b>	<b>83.9</b>	<b>1,416.3</b>
НИЙТ ЗАРЛАГА	5,386.1	8,672.7	7,334.5	84.6	1,338.1
УРСГАЛ ЗАРДАЛ	4,518.2	6,614.0	5,852.8	88.5	761.2
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,146.4</b>	<b>2,968.0</b>	<b>2,501.9</b>	<b>84.3</b>	<b>466.1</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,311.1	1,625.5	1,515.2	93.2	110.3
Үндсэн цалин	964.5	1,098.5	1,068.3	97.3	30.2
Нэмэгдэл	249.7	391.6	330.6	84.4	61.0
Унаа хоолны хөнгөлөлт	31.0	38.2	33.7	88.2	4.5
Урамшуулал	50.1	78.8	66.3	84.1	12.5
Гэрээт ажлын хөлс	15.8	18.5	16.4	88.8	2.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэврийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэмжийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
ҮОМШӨ-ний даатгал	0.0	0.0	0.0	-	0.0

Ажилгүйдлийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Эрүүл мэндийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>140.2</b>	<b>190.1</b>	<b>149.3</b>	<b>78.5</b>	<b>40.8</b>
Гэрэл, цахилгаан	27.7	37.4	29.3	78.3	8.1
Түлш, халаалт	87.6	112.7	93.3	82.8	19.4
Цэвэр, бохир ус	12.7	18.4	11.0	60.1	7.3
Байрны түрээс	12.2	21.6	15.6	72.5	5.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>72.0</b>	<b>112.6</b>	<b>87.8</b>	<b>78.0</b>	<b>24.8</b>
Бичиг хэрэг	6.6	9.3	7.3	78.7	2.0
Тээвэр, шагахуун	27.0	43.5	33.4	76.9	10.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6.7	9.6	7.4	77.1	2.2
Ном, хэвлэл	1.0	5.5	2.6	46.5	2.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24.7	34.8	29.2	83.8	5.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6.0	9.9	7.8	79.5	2.0
<b>Нормативт зардал</b>	<b>152.3</b>	<b>236.2</b>	<b>196.9</b>	<b>0.0</b>	<b>39.3</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79.0	90.4	80.6	89.2	9.7
Хоол, хүнс	53.9	108.4	89.5	82.6	18.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	19.3	37.5	26.8	71.4	10.7
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>39.1</b>	<b>61.0</b>	<b>40.6</b>	<b>66.6</b>	<b>20.3</b>
Багаж, техник, хэрэгсэл	13.0	30.7	20.7	67.5	10.0
Тавилга	2.2	1.2	1.1	89.3	0.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.4	2.4	1.6	65.9	0.8
Урсгал засвар	23.5	26.7	17.3	64.7	9.4
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16.5</b>	<b>14.5</b>	<b>8.1</b>	<b>55.8</b>	<b>6.4</b>
Гадаад албан томилолт	6.0	5.1	2.5	49.0	2.6
Дотоод албан томилолт	7.5	7.4	4.2	56.6	3.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	3.0	2.0	1.4	69.9	0.6
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>242.4</b>	<b>429.1</b>	<b>302.8</b>	<b>70.6</b>	<b>126.3</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	222.7	391.2	277.8	71.0	113.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1.0	2.3	1.6	66.7	0.8
Даатгалын үйлчилгээ	6.7	10.2	7.4	72.3	2.8
Тээврийн хэрэгслийн татвар	0.4	1.2	0.8	69.5	0.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.2	0.2	0.1	45.8	0.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4.9	12.6	7.5	59.1	5.2
Газрын төлбөр	0.5	1.4	0.5	38.4	0.8
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.9	1.2	1.0	82.9	0.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5.0	8.7	6.2	70.6	2.6
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>172.8</b>	<b>299.0</b>	<b>201.2</b>	<b>67.3</b>	<b>97.8</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	154.7	271.0	184.7	68.1	86.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18.1	28.0	16.5	59.0	11.5
<b>ХҮҮ</b>	<b>462.0</b>	<b>516.8</b>	<b>459.3</b>	<b>88.9</b>	<b>57.5</b>
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	364.4	427.8	408.6	95.5	19.2
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	97.5	89.0	50.7	57.0	38.3
<b>ТАТААС</b>	<b>142.4</b>	<b>270.3</b>	<b>229.0</b>	<b>84.7</b>	<b>41.3</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	38.0	78.2	64.0	81.9	14.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	104.4	192.1	165.0	85.9	27.1
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,767.5</b>	<b>2,859.0</b>	<b>2,662.6</b>	<b>93.1</b>	<b>196.4</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>46.2</b>	<b>151.1</b>	<b>93.9</b>	<b>62.1</b>	<b>57.2</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	42.6	146.7	91.5	62.4	55.2
Засгийн газрын гадаад шилжүүлэг	3.6	4.4	2.4	55.1	2.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,721.3</b>	<b>2,707.9</b>	<b>2,568.7</b>	<b>94.9</b>	<b>139.2</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1,167.8	1,443.7	1,398.5	96.9	45.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	398.2	839.7	800.3	95.3	39.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2.5	4.8	2.8	58.9	2.0



Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	65.0	304.0	273.6	90.0	30.4
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57.8	76.8	61.9	80.5	15.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24.2	27.0	23.3	86.6	3.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5.9	11.9	8.2	69.0	3.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>867.9</b>	<b>2,058.6</b>	<b>1,481.7</b>	<b>72.0</b>	<b>576.9</b>
Барилга байгууламж	623.1	1,350.7	905.3	67.0	445.4
Их засвар	44.7	72.2	49.0	67.9	23.2
Тоног төхөөрөмж	45.5	266.9	199.0	74.6	67.9
Бусад хөрөнгө	144.2	351.3	314.5	89.5	36.8
Стратегийн нөөц хөрөнгө	10.4	17.6	14.0	79.5	3.6
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>113.7</b>	<b>109.5</b>	<b>31.3</b>	<b>28.6</b>	<b>78.1</b>
Эргэж төлөгдөх зээл	61.3	-59.9	-27.6	46.1	-32.3
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	52.4	169.4	58.9	34.8	110.4


Эх сурвалж: Сангийн яам

**Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 79.5 хувьд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2.7 пунктээр буурсан байна.**

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 5,852.8 тэрбум төгрөг буюу 79.5 хувь нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 42.7 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 45.5 хувийг урсгал шилжүүлэг, 7.8 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.9 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,334.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: зээлийн үйлчилгээний төлбөр 2.6 тэрбум төгрөгөөр буурсан ч бараа, үйлчилгээний зардал 355.5 тэрбум, татаас 86.7 тэрбум, урсгал шилжүүлэг 895.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц /хувиар/



**Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан улсын төсвийн нийт зарлагын төсөв 843.3 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.**

Улсын төсвийн нийт зарлагын 24.3 хувийг Сангийн сайдын багц, 22.2 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 16.9 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багц, 7.8 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 6.1 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц болон Монгол Улсын Ерөнхий сайдын багц тус тус 4.6 хувийг, Батлан хамгаалахын сайдын багц 2.5 хувийг, үлдэх 10.9 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын төсвийн зардал эзэлж байна.

## Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

## Хүснэгт 6.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	2020 оны эхний 7 сарын гүйцэтгэл			
	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	4,883.6	3,383.5	1.5	69.3
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	25,695.6	22,168.1	3.5	86.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	367,172.8	270,850.6	96.3	73.8
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	37,517.0	21,953.2	15.6	58.5
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	52,152.1	39,650.3	12.5	76.0
САНГИЙН САЙД	1,785,143.1	1,427,655.4	357.5	80.0
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	172,474.8	147,426.8	25.0	85.5
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	498,796.3	459,303.1	39.5	92.1
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1,276.2	1,240.1	0.0	97.2
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	2,847.4	2,032.0	0.8	71.4
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	32,674.1	30,001.3	2.7	91.8
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	21,589.3	19,287.9	2.3	89.3
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	4,070.4	3,836.4	0.2	94.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	13,568.1	11,126.1	2.4	82.0
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	10,762.2	9,157.6	1.6	85.1
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	2,925.3	2,388.7	0.5	81.7
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	2,690.0	1,373.4	1.3	51.1
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА	54,192.6	48,773.1	5.4	90.0
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	113,207.5	94,612.1	18.6	83.6
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	23,142.1	18,480.0	4.7	79.9
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	715.5	706.5	0.0	98.7
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	17,632.6	11,578.4	6.1	65.7
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	72,856.6	63,967.2	8.9	87.8
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	393,463.2	359,869.2	33.6	91.5
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	77,069.5	69,366.2	7.7	90.0
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	1,028,284.2	993,429.1	34.9	96.6
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	135,756.7	126,653.5	9.1	93.3
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	11,422.0	10,196.0	1.2	89.3
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	332,367.7	270,360.6	62.0	81.3
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	33,695.8	26,470.9	7.2	78.6
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	1,381,078.4	1,300,555.4	80.5	94.2
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>6,711,122.7</b>	<b>5,867,852.8</b>	<b>843.3</b>	<b>87.4</b>

Эх сурвалж: Сангийн яам

## 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр нийт 438.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 415.0 тэрбум төгрөгийг зарцуулж, 94.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

**МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ЭХНИЙ 7 САРЫН УЛСЫН ТӨСВИЙН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ /Сая төгрөгөөр/**

Хөрөнгө оруулалт		ТЕЗ	Санхүүжих дүн	Гүйцэтгэлийн хувь
119,913.3	5,541.9	БСШУС-ын сайд	662,421.5	95.6
95,385.7	3,011.5	ЗТХ-ийн сайд	310,979.8	96.9
60,829.6	4,312.9	БХБ-ын сайд	250,987.5	93.4
32,324.5	721.8	ХЗДХ-ийн сайд	51,035.2	97.8
28,441.1	998.2	Эрүүл мэндийн сайд	133,756.2	96.6
26,056.8	5,008.8	Сангийн сайд	175,100.0	83.9
15,486.4	0.0	Монгол Улсын Ерөнхий сайд	23,459.0	100.0
10,148.3	890.0	ЗГХЭГ-ын дарга	32,529.5	91.9
7,926.3	2,409.7	Эрчим хүчний сайд	72,623.5	76.7
5,305.7	30.5	Монгол Улсын Шадар сайд	9,934.9	99.4
3,535.0	198.4	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	25,426.8	94.7
2,986.1	0.0	Батлан хамгаалахын сайд	11,080.0	100.0
1,540.2	32.5	Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд	25,456.9	97.9
1,522.2	159.1	ХХААХҮ-ийн сайд	15,192.9	90.5
1,503.7	24.3	Гадаад харилцааны яам	2,600.0	98.4
1,029.4	0.0	Авлигатай тэмцэх газрын дарга	1,120.7	100.0
415.4	0.0	Монгол Улсын Ерөнхий Аудитор	1,000.0	100.0
331.6	0.0	Үндэсний Статистикийн хорооны дарга	650.7	100.0
236.3	63.7	Улсын Ерөнхий прокурор	11,731.5	78.8
124.9	0.0	Үндсэн хуулийн цэцийн дарга	600.0	100.0
7.2	152.4	Монгол Улсын Их Хурлын дарга	2,560.8	4.5
0		Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	4,202.9	0
0		Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч	4,480.0	0
<b>415,049.8</b>	<b>23,555.8</b>		<b>94.6 %</b>	
Эхний 7 сарын санхүүжилт		Санхүүжүүлээгүй		Эхний 7 сарын санхүүжилтийн хувь

Эх сурвалж: Сангийн яам



## “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” КОНЦЕССЫН ТӨРЛӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэл

Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид эхний 7 сарын гүйцэтгэлээр 239.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 202.2 тэрбум төгрөгийг санхүүжүүлж, 84.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

### “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ”

<p>Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам</p>  <p><b>111.1 тэрбум төгрөг, 99.1 хувь</b></p>	<p>Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/</p>  <p><b>2.6 тэрбум төгрөг, 100.0 хувь</b></p>
<p>Алтай-Дарви чиглэлийн 98км хатуу хучилттай авто зам төсөл</p>  <p><b>32.0 тэрбум төгрөг, 100.0 хувь</b></p>	<p>"Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлт</p>  <p><b>30.5 тэрбум төгрөг, 100.0 хувь</b></p>
<p>Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам төсөл</p>  <p><b>18.0 тэрбум төгрөг, 33.4 хувь</b></p>	<p>Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц</p>  <p><b>8.0 тэрбум төгрөг, 100.0 хувь</b></p>


2020 оны эхний 7 сард нийт 6 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 33.4-100 хувийн биелэлттэй гарчээ.

Нийт олгосон санхүүжилтийн 54.9 хувийг Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто замын төсөл, 15.8 хувийг Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто замын төсөл, 15.1 хувийг “Чойр” дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн төсөл, 8.9 хувийг Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам төсөл, 4.0 хувийг Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц төсөл, 1.3 хувийг Баянгол дүүргийн 38 дугаар сургуулийн барилгын төсөл, арга хэмжээ тус тус эзэлж байна.

Улсын Их Хурал, ХШҮХ  
Төсвийн шинжилгээний алба

Эх сурвалж: Сангийн яам


5. Нийгмийн даатгалын сан



Эх сурвалж: Сангийн яам




Нийгмийн даатгалын сангийн зарлагад 1,413.3 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 231.6 тэрбум төгрөг буюу 19.6 хувиар өссөн байна. Үүнд, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 74.2 тэрбум төгрөгөөр буурсан ч, тэтгэврийн даатгалын сангийн зарлага 183.3 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 12.7 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 1.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.



### 6. Эрүүл мэндийн даатгалын сан

**Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:**

**График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөг/**




Эрүүл мэндийн даатгалын санд 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 249.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 15.6 хувь буюу 46.0 тэрбум төгрөгөөр дутуу биелж, орлогын гүйцэтгэл 84.4 хувьтай гарчээ.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:**

2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 298.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 222.9 тэрбум төгрөгийг зарцуулснаар тус сангийн гүйцэтгэл 74.6 хувьтай гарчээ. Харин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 32.1 тэрбум төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн байна.

**График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөг/**



### 7. Орон нутгийн төсөв

**2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 715.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.**

2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 1,860.3 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 11.1 хувь буюу 233.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн



бол орон нутгийн төсвийн нийт зарлага 1,641.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 30.4 хувь буюу 715.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсанаар орон нутгийн төсвийн тэнцэл 218.6 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 12.1 хувиар буюу 200.7 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 12.4 хувь буюу 181.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 41.1 хувийг орон нутгийн төсвийн орлого, 47.0 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 8.2 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 3.7 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 152.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг төлөвлөснийг 100.0 хувь олгосон бол орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 68.4 тэрбум төгрөгийг шилжүүлсэн нь төлөвлөснөөс 27.9 хувиар дутуу олгогджээ.



Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 233.3 тэрбум төгрөг буюу 11.1 хувиар дутуу төвлөрсөн нь орон нутгийн орлого 21.3 хувь буюу 206.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг 27.9 хувь буюу 26.5 тэрбум төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлэг 7.5 сая төгрөгөөр тус тус дутуу шилжсэнтэй холбоотой байна.

Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

**Хүснэгт 7.**

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	10,011.0	10,011.0	100.0	31,234.0	31,234.0	100.0	2,584.0	1,858.5	71.9
Баян-Өлгий	5,677.0	5,677.0	100.0	42,480.9	42,480.9	100.0	3,245.7	2,443.6	75.3
Баянхонгор	14,359.4	14,359.4	100.0	31,094.9	31,094.9	100.0	3,767.1	2,688.9	71.4
Булган	3,430.3	3,430.3	100.0	20,511.7	20,511.7	100.0	1,825.4	1,277.6	70.0
Говь-Алтай	11,404.4	11,404.4	100.0	23,476.8	23,476.8	100.0	4,397.4	3,269.9	74.4
Дорноговь	0.0	0.0	0.0	21,694.3	21,694.3	100.0	8,773.0	5,856.8	66.8
Дорнод	0.0	0.0	0.0	25,271.4	25,271.4	100.0	4,035.3	2,953.7	73.2
Дундговь	8,823.2	8,823.2	100.0	17,628.2	17,628.2	100.0	3,204.1	2,306.4	72.0
Завхан	14,356.1	14,356.1	100.0	28,004.7	28,004.1	100.0	2,488.2	1,927.4	77.5
Өвөрхангай	12,639.0	12,639.0	100.0	35,271.0	35,271.0	100.0	3,213.6	2,495.4	77.7
Өмнөговь	0.0	0.0	0.0	22,346.4	22,346.4	100.0	8,204.9	5,132.4	62.6
Сүхбаатар	7,886.0	7,886.0	100.0	19,939.8	19,939.8	100.0	6,996.2	5,160.5	73.8
Сэлэнгэ	4,091.5	4,091.5	100.0	35,167.0	35,167.0	100.0	4,245.9	3,403.6	80.2
Төв	7,600.2	7,600.2	100.0	32,400.9	32,400.9	100.0	4,003.7	2,021.7	50.5
Увс	18,509.3	18,509.3	100.0	32,301.0	32,301.0	100.0	3,061.9	2,409.8	78.7

Ховд	8,069.8	8,069.8	100.0	31,511.7	31,511.7	100.0	5,154.8	3,886.2	75.4
Хөвсгөл	14,164.5	14,164.5	100.0	47,593.1	47,593.1	100.0	3,849.6	2,965.8	77.0
Хэнтий	9,381.6	9,381.6	100.0	26,785.1	26,785.1	100.0	4,082.5	3,157.9	77.4
Дархан-Уул	0.0	0.0	0.0	25,508.3	25,508.3	100.0	3,424.7	2,666.7	77.9
Улаанбаатар	0.0	0.0	0.0	292,656.9	292,650.0	100.0	11,416.5	8,247.2	72.2
Орхон	0.0	0.0	0.0	26,683.3	26,683.3	100.0	2,372.1	1,865.6	78.6
Говьсүмбэр	1,712.4	1,712.4	100.0	5,708.3	5,708.3	100.0	633.4	447.4	70.6
<b>ДҮН</b>	<b>152,115.7</b>	<b>152,115.7</b>	<b>100.0</b>	<b>875,269.8</b>	<b>875,262.3</b>	<b>100.0</b>	<b>94,979.9</b>	<b>68,442.9</b>	<b>72.1</b>

Эх сурвалж: Сангийн яам

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 875.3 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгожээ. Харин орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилахаар 95.0 тэрбум төгрөг төсөвлөсөн боловч 72.1 хувь буюу 68.4 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал; Баян-Өлгий аймаг 1,094.2 сая, Баянхонгор аймаг 1,966.9 сая, Говь-Алтай аймаг 948.4 сая, Дорноговь аймаг 6,873.7 сая, Дорнод аймаг 1,122.1 сая, Дундговь аймаг 711.1 сая, Завхан аймаг 330.1 сая, Өвөрхангай аймаг 636.8 сая, Өмнөговь аймаг 34,604.7 сая, Сүхбаатар аймаг 5,589.2 сая, Сэлэнгэ аймаг 973.1 сая, Төв аймаг 1,828.3 сая, Увс аймаг 7.2 сая, Ховд аймаг 1,958.6 сая, Хөвсгөл аймаг 324.1 сая, Хэнтий аймаг 3,748.3 сая, Дархан-Уул аймаг 3,488.4 сая, Улаанбаатар хот 186,608.8 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн бол Архангай аймаг 11.7 сая, Булган аймаг 922.5 сая, Орхон аймаг 17,855.2 сая, Говьсүмбэр аймаг 729.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлд дүнд шинжилгээ хийхэд дараах дүгнэлт өгөхөөр байна. Үүнд:

**Төсвийн орлогын хувьд:** 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 4,900.3 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 1,337.5 тэрбум төгрөгөөр дутуу биелж, өмнөх оны мөн үеэс 1,134.8 тэрбум төгрөг буюу 18.8 хувиар буурсан байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 21.4 хувиар дутуу биелж, 78.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 1,337.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд татварын орлогын 19.4 хувь буюу 1,082.5 тэрбум төгрөг, татварын бус орлогын 38.7 хувь буюу 255.0 тэрбум төгрөгийн дутуу биелэлтүүд нөлөөлжээ.
- Тайлант хугацаанд бүх төрлийн татварын орлого 0.2-27.2 хувиар төлөвлөсөн дүнгээс дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 61.3 хувийн биелэлттэй гарч, 255.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь хүүгийн орлогоос бусад татварын бус орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

**Төсвийн нийт зарлагын хувьд:** Нэгдсэн төсвийн нийт зарлага 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 1,416.3 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 83.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 16.1 хувиар дутуу зарцуулагдсан ч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.9 хувиар буюу 1,866.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 94.6 хувийн гүйцэтгэлтэй гарч, 415.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогджээ.
- Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үеэс 2.6 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувийн, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 57.5 тэрбум төгрөгөөр буюу 11.1 хувийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

---oOo---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА